



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

1 Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	7
2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчилийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

2019.04.25 № 841  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ ӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-наас 2019 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Сэржмядаг, Г.Мөнхчимэг нар гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 2/1534 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх журам,





түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар Прокурорын байгууллагыг "Монгол Улсын төрийн байгуулал" гэсэн гуравдугаар бүлгийн "Шүүх эрх мэдэл" гэсэн хэсэгт хамааруулан 56 дугаар зүйлийн 56.3-д "Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж заасны дагуу 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргаж 2017 он хүртэлх хугацаанд 8 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Монгол Улсын Прокурорын тухай шинэчлэн батлагдсан 2017 оны хуульд үйл ажиллагааны үндсэн зарчим, хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой зохицуулж өгсөн ба 15 зүйл бүхий 20 заалтаар үндсэн чиг үүргийг тодорхойлжээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2018 онд хэрэгжүүлсэн зарим хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналт 100 хувь;
- Ял эдлүүлэх ажиллагаанд буюу хорих анги, цагдан хорих байрнуудын үйл ажиллагаанд хяналт тавих тоог 6845 төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9801 удаагийн шалгалт болон хяналтын ажлыг хийж 143 хувийн биелэлттэй;
- Улсын хэмжээнд шийдвэрлэх зөрчлийн тоог 800,000 төлөвлөснөөс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, прокурорын байгууллагын нэгжүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, зөрчил шалган шийдвэрлэх 27 эрх бүхий байгууллагын 11,000 гаруй албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж нийт 1,538,320 зөрчлийг шийдвэрлэж 192 хувийн биелэлттэй тус тус ажилласан байна.

Мөн Төсвийн тухай хуульд зааснаар 2 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөснөөс 98.92 хувийн биелэлттэй ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого,



журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын хэмжээнд 2016 онд боловсруулж Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм ашиглажээ.

Харин үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон нь тухайн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд улсын төсвөөс санхүүжилт авдагтай холбоотой гэж үзлээ.

Тиймээс 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,718.3 сая төгрөг бөгөөд түүний 1.5 хувь болох 490.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон болно.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.5 хувиар тооцсон нь эрсдэл бага, дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзсэнтэй холбоотой ба аудитыг төлөвлөх үе шатны материаллаг



байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбараас гадна чанарын үзүүлэлтийг тусгасан.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 43 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 36 санхүүгийн тайлан аудитад хамрагдаж 7 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	33	2	7	
2	Төсвийн ерөнхийлөн захирагч	1			
<b>Дүн</b>		<b>34</b>	<b>2</b>	<b>7</b>	<b>0</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудитаар 33 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт гаргасан байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,801.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 93.5 хувь буюу 1,684.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын явцад залруулж, 0.2 хувь буюу 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.8 хувь буюу 31.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 4.5 хувь буюу 81.6 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:					
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагч	49	116.7	6	3.2	5	31.9	38	81.6
2	Төсвийн ерөнхийлөн захирагч	1						1	
<b>Дүн</b>		<b>50</b>	<b>116.7</b>	<b>6</b>	<b>3.2</b>	<b>5</b>	<b>31.9</b>	<b>39</b>	<b>81.6</b>

Эх сурвалж: 2018 оны Аудит хийсэн санхүүгийн тайлан





## 2.8.2 Төсвийн ерөнхий захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний, анхаарал татахуйц дараах алдаа зөрчилтэй асуудал байна. Үүнд:

- ✚ Дорноговь аймгийн Прокурорын газрын нягтлан бодогч нь ажилтнуудын нэр дээр цалин илүү бодож өөрийн дансанд авч ашигласнаас 7.7 сая төгрөгийн авлага үүссэн, мөн байгууллага хувь хүний дансанд 3.8 сая төгрөгийг шилжүүлэн авсан зэрэг зөрчлүүдийг дотоод аудитаар илрүүлсэн ба уг асуудлыг цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгаж байгаагаас шалтгаалан санхүүгийн тайланд нь сөрөг санал дүгнэлт өгсөн байна.
- ✚ Анхан шатны нотлох баримтгүй зардал гаргасан, шатахууны зардал баримтаар нотлогдоогүй, ээлжийн амралт, цалин илүү олгосон гэх мэт нийт 3.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. /Говь-Алтай аймгийн Прокурорын газар 0.3 сая, Орхон аймгийн Прокурорын газар 0.6 сая, Ховд аймгийн Прокурорын газар 0.7 сая, Баянзүрх дүүргийн Прокурорын газар 0.6 сая, Булган сум дундын Прокурорын газар 0.3 сая, Замын-Үүд сум дундын прокурорын газар 0.6 сая төгрөг/
- ✚ Шатахууны тооцооны анхан шатны баримт бүрдүүлээгүй, бараа материалын тайлан гаргаагүй, худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийгээгүй, цалингийн урьдчилгааг удирдлагын зөвшөөрөлгүй олгосон, авлага, өглөгийг барагдуулаагүй гэх мэт нийт 31.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. /Говь-Алтай, Орхон аймгийн Прокурорын газар, Баянзүрх дүүргийн прокурорын газар 27.8 сая, Налайх-Багахангай дүүргийн прокурорын газар 3.3 сая, Ханбогд сум дундын прокурорын газар 0.8 сая /

## 2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний 2018 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 6 арга хэмжээ түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.



Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 29,238.0 сая төгрөг, үүнээс улсын төсвөөс 28,937.8 сая төгрөг, тусламжийн эх үүсвэрээс 300.2 сая төгрөгийн төсөв батлагдсан ба тусламжийн эх үүсвэрийн санхүүжилт олгогдоогүй, улсын төсвөөс 28,936.6 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэл 28,923.1 сая төгрөг буюу 98.9 хувийн биелэлттэй гарсан байна.

Мөн тайлант онд харьяа прокурорын газрууд Засаг даргын нөөцөөс 180.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 20.7 сая төгрөг нийт 201.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр авч зарцуулсан байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудас болон “shilendans.gov.mn” цахим хуудсанд мэдээлж байна.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын өмнөх оны аудитаар 50.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгснийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 95.4 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Харьяа газруудад илэрсэн зөрчил**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 42 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 32 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 1 санхүүгийн тайланд “Сөрөг санал”, дүгнэлт өгч, 7 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 2 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитаар харьяа газруудын нийт 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 81.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,226,475.8</b>	<b>3,919,307.0</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>340,898.8</b>	<b>486,736.8</b>
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>340,898.8</b>	<b>486,736.8</b>
<b>Төгрөг</b>	<b>299,037.5</b>	<b>419,737.6</b>
Арилжааны банк дахь харилцах	285,039.3	407,061.4
Бусад төсөл, нөөцийн харилцах	13,998.2	12,676.2
<b>Гадаад валют</b>	<b>41,861.3</b>	<b>66,999.3</b>
Арилжааны банк дахь харилцах	41,861.3	66,999.3
<b>АВЛАГА</b>	<b>84,346.1</b>	<b>21,869.3</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	49,321.1	16,014.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	126.0	349.2
<b>Бусад авлага</b>	<b>34,899.0</b>	<b>5,505.2</b>
Байгууллагаас авах авлага	32,632.1	3,769.2
Хувь хүмүүсээс авах авлага	2,266.9	1,736.0
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>11,754.3</b>	<b>19,565.3</b>
Урьдчилж гарсан зардал	10,100.0	17,911.0
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>1,654.3</b>	<b>1,654.3</b>
Томилолтын урьдчилгаа	1,654.3	1,654.3
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>383,601.2</b>	<b>695,260.2</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>293.7</b>	<b>293.7</b>
Тусгай зориулалттай материал	293.7	293.7
Бэлэн бүтээгдэхүүн	52,093.4	227,686.3
<b>Хангамжийн материал</b>	<b>321,559.1</b>	<b>457,201.2</b>
Бичиг хэргийн материал	39,414.8	50,847.8
Аж ахуйн материал	183,016.3	219,699.4
Сэлбэг хэрэгсэл	11,540.7	17,042.7
Түлш, шатах тослох материал	15,658.6	15,287.5
Барилгын засварын материал	5,899.9	1,535.0
Бусад хангамжийн материал	66,028.9	152,788.8
Мал амьтад	9,655.0	10,079.0
<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>2,405,875.4</b>	<b>2,695,875.4</b>
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,405,875.4	2,695,875.4
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,585,007.5</b>	<b>22,358,318.3</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>18,585,007.5</b>	<b>22,358,318.3</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>18,570,713.5</b>	<b>19,235,006.6</b>
Барилга, байгууламж, орон сууц	20,497,587.1	16,283,552.2
Хуримтлагдсан элэгдэл	-3,846,946.6	-228,439.2
Авто-тээврийн хэрэгсэл	3,583,837.6	4,057,876.1
Хуримтлагдсан элэгдэл	-3,185,124.0	-3,204,594.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,539,025.6	3,454,671.2
Хуримтлагдсан элэгдэл	-2,150,335.2	-2,157,737.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,018,040.7	2,011,925.0
Хуримтлагдсан элэгдэл	-977,906.3	-1,102,521.3
Бусад үндсэн хөрөнгө	128,390.8	168,208.3
Хуримтлагдсан элэгдэл	-47,821.5	-59,429.2
Ном	11,965.3	11,495.3
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>14,294.0</b>	<b>3,123,311.7</b>
Програм хангамж	197,433.0	180,946.5



Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит

Хуримтлагдсан элэгдэл	-196,256.0	-180,139.0
Бусад биет бус хөрөнгө	16,027.0	3,125,414.3
Хуримтлагдсан элэгдэл	-2,910.0	-2,910.0
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>21,811,483.3</b>	<b>26,277,625.3</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>334,783.5</b>	<b>714,890.7</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>334,783.5</b>	<b>483,675.8</b>
<b>Өглөг</b>	<b>43,301.0</b>	<b>35,481.9</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	11,386.9	4,071.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,520.2	1,878.8
Зээлийн хүүгийн өглөг	0.0	2,132.7
<b>Бусад өглөг</b>	<b>27,393.9</b>	<b>27,398.8</b>
Байгууллагад төлөх өглөг	27,381.0	27,276.4
Хувь хүмүүст төлөх өглөг	12.9	122.4
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>291,482.5</b>	<b>448,193.9</b>
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	291,482.5	448,193.9
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>231,214.9</b>
<b>Урт хугацаат зээл</b>	<b>0.0</b>	<b>231,214.9</b>
<b>Гадаад валют</b>	<b>0.0</b>	<b>231,214.9</b>
Санхүүгийн зээл	0.0	231,214.9
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>21,476,699.8</b>	<b>25,562,734.6</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>21,476,699.8</b>	<b>25,562,734.6</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,625,705.8	15,735,093.1
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,956,603.0</b>	<b>5,054,164.6</b>
Өмнөх үеийн үр дүн	5,175,930.5	7,207,237.5
Тайлант үеийн үр дүн	1,780,672.6	-2,153,072.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,894,391.0	4,773,476.9
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>21,811,483.3</b>	<b>26,277,625.3</b>





#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>29,880,596.3</b>	<b>30,565,222.0</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,925,289.3</b>	<b>1,426,984.7</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,925,289.3</b>	<b>1,426,984.7</b>
<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,868,049.0</b>	<b>1,393,968.8</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	11,734.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,868,049.0	1,382,234.0
Бусад орлого	57,240.3	33,015.9
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>26,955,307.0</b>	<b>29,138,237.2</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>26,723,241.7</b>	<b>28,936,616.7</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,634,970.7	28,485,807.4
Хөрөнгийн санхүүжилт	88,271.0	450,809.3
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>232,065.3</b>	<b>195,434.5</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,457.9	180,381.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,607.5	15,052.8
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.0</b>	<b>6,186.0</b>
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.0	2,621.1
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	0.0	3,565.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>28,049,754.3</b>	<b>29,068,759.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,049,754.3</b>	<b>28,937,939.8</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>27,461,324.8</b>	<b>28,404,112.7</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>20,977,791.6</b>	<b>21,840,874.9</b>
Үндсэн цалин	19,233,587.8	18,724,239.1
Нэмэгдэл	1,076,951.9	2,764,554.9
Унаа хоолны хөнгөлөлт	593,800.1	325,728.2
Гэрээт ажлын хөлс	73,451.9	26,352.7
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,310,925.4</b>	<b>2,630,023.3</b>
Тэтгэврийн даатгал	1,896,232.1	2,187,954.0
Тэтгэмжийн даатгал	84,273.1	111,045.6
ҮОМШӨ-ний даатгал	92,958.9	99,804.4
Ажилгүйдлийн даатгал	28,848.8	22,169.2
Эрүүл мэндийн даатгал	208,612.5	209,050.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>838,643.6</b>	<b>858,605.0</b>
Гэрэл, цахилгаан	151,583.8	177,569.4
Түлш, халаалт	549,548.8	563,934.4
Цэвэр, бохир ус	72,809.4	67,723.6
Байрны түрээс	64,701.6	49,377.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,047,966.3</b>	<b>1,186,210.4</b>
Бичиг хэрэг	209,772.1	360,837.3
Тээвэр, шатахуун	246,177.8	310,894.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	342,553.7	330,595.3
Ном, хэвлэл	1,828.9	5,488.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,751.0	6,837.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,361.6	160,466.0
Аж ахуйн материал худалдан авах зардал	210.0	0.0
Бараа материал акталсны зардал	40,462.8	11,092.2



Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал шилжүүлсний зардал	94,848.4	0.0
<b>Нормативт зардал</b>	<b>29,614.5</b>	<b>19,926.0</b>
Хоол, хүнс	446.0	212.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,168.5	19,714.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>517,251.7</b>	<b>404,489.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,997.0	680.0
Урсгал засвар	515,254.7	403,809.8
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>95,926.0</b>	<b>160,826.4</b>
Гадаад албан томилолт	13,151.8	58,889.1
Дотоод албан томилолт	61,450.1	90,949.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	21,324.2	10,988.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>68,649.7</b>	<b>190,629.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,321.8	113,361.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,963.5	6,201.5
Даатгалын үйлчилгээ	25,048.4	32,702.6
Тээврийн хэрэгслийн татвар	6,553.9	8,552.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	887.9	1,241.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,213.3	25,870.8
Газрын төлбөр	5,622.1	2,699.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38.7	0.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,574,555.9</b>	<b>1,112,527.4</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	215,208.3	159,109.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88,785.4	110,595.2
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,270,562.3	842,822.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>588,429.5</b>	<b>533,827.1</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>575,456.1</b>	<b>518,824.0</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.0	3,565.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,565.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	367,675.0	400,791.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	206,216.1	114,467.3
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,854.5</b>	<b>14,974.6</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	8,854.5	14,974.6
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,118.9</b>	<b>28.6</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,118.9	28.6
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>130,819.3</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.0</b>	<b>130,819.3</b>
Их засвар	0.0	130,819.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,830,842.0</b>	<b>1,496,462.9</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>50,169.5</b>	<b>3,649,535.8</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,169.5	2,858.6
Үнэ төлбөргүй гарсан зардал	0.0	2,802.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.0	3,643,874.7
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,780,672.6</b>	<b>-2,153,072.9</b>



#### 4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>27,346,396.2</b>	<b>29,506,850.8</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>353,073.3</b>	<b>326,594.7</b>
Нийтлэг татварын бус орлого	353,073.3	326,594.7
Бусад орлого	353,073.3	326,594.7
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>26,993,323.0</b>	<b>29,180,256.0</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>26,723,241.7</b>	<b>28,936,616.7</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,634,970.7	28,485,807.4
Хөрөнгийн санхүүжилт	88,271.0	450,809.3
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>232,909.3</b>	<b>201,164.7</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,301.9	180,381.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,607.5	20,782.9
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>37,172.0</b>	<b>42,474.7</b>
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	37,172.0	42,474.7
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,097,121.2</b>	<b>28,516,835.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>27,097,121.2</b>	<b>28,516,835.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>26,242,273.6</b>	<b>27,820,525.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>20,957,962.5</b>	<b>21,809,517.5</b>
Үндсэн цалин	18,691,293.3	15,838,567.5
Нэмэгдэл	1,596,044.7	5,223,718.7
Унаа хоолны хөнгөлөлт	556,970.8	628,274.0
Гэрээт ажлын хөлс	113,653.6	118,957.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,304,073.3</b>	<b>2,621,007.7</b>
Тэтгэврийн даатгал	1,900,513.1	1,946,442.7
Тэтгэмжийн даатгал	95,331.9	171,290.3
ҮОМШӨ-ний даатгал	83,894.2	139,076.9
Ажилгүйдлийн даатгал	22,449.9	35,195.6
Эрүүл мэндийн даатгал	201,884.4	329,002.2
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>851,818.6</b>	<b>864,450.4</b>
Гэрэл, цахилгаан	153,633.9	174,439.9
Түлш, халаалт	554,260.5	572,283.5
Цэвэр, бохир ус	72,519.4	68,040.2
Байрны түрээс	71,404.9	49,686.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>991,931.0</b>	<b>1,207,741.4</b>
Бичиг хэрэг	214,508.0	360,468.4
Тээвэр, шатахуун	238,048.4	287,558.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	405,192.4	333,421.4
Ном, хэвлэл	2,818.4	7,029.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,831.6	7,355.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	127,532.2	211,907.2
<b>Нормативт зардал</b>	<b>8,205.9</b>	<b>205,345.9</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,205.9	205,345.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>607,751.6</b>	<b>407,170.0</b>
Багаж, техник, хэрэгсэл	3,162.7	4,076.1
Урсгал засвар	604,589.0	403,093.8



<b>Томилолт, зочны зардал</b>	<b>111,675.7</b>	<b>159,186.3</b>
Гадаад албан томилолт	30,598.1	58,803.0
Дотоод албан томилолт	59,389.3	88,854.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	21,688.3	11,528.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>69,783.2</b>	<b>276,432.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,740.6	201,199.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,719.5	4,772.4
Даатгалын үйлчилгээ	25,048.4	32,702.6
Тээврийн хэрэгслийн татвар	6,534.1	8,554.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	843.9	1,241.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,257.8	25,223.5
Газрын төлбөр	5,600.1	2,739.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38.7	0.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>339,071.8</b>	<b>269,673.8</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	241,502.6	154,355.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	97,569.2	115,318.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>854,847.5</b>	<b>696,309.6</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>180,339.5</b>	<b>113,927.9</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	180,339.5	113,927.9
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>661,534.7</b>	<b>567,378.6</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	36,256.7	40,084.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	373,254.0	403,791.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	252,023.9	123,502.4
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,854.5</b>	<b>14,968.9</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	8,854.5	14,968.9
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,118.9</b>	<b>34.2</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,118.9	34.2
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>249,275.0</b>	<b>990,015.3</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>166,527.0</b>	<b>847,106.9</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>166,527.0</b>	<b>847,106.9</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>166,527.0</b>	<b>847,106.9</b>
Барилга байгууламж	88,271.0	290,000.0
Их засвар	0.0	130,819.3
Тоног төхөөрөмж	0.0	29,990.0
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	78,256.0	396,297.6
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-166,527.0</b>	<b>-847,106.9</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>3,891.0</b>	<b>2,929.6</b>
<b>Бусад эх үүсвэр</b>	<b>3,934.7</b>	<b>2,929.6</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,934.7	2,929.6
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>43.7</b>	<b>0.0</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	43.7	0.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>86,639.0</b>	<b>145,838.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	254,259.8	340,898.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	340,898.8	486,736.8



#### 4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,596,000.3		19,596,000.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,754.1		100,754.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,696,754.4		19,696,754.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-727.1		-727.1
Тайлант үеийн үр дүн	1,780,672.6		1,780,672.6
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,476,699.8		21,476,699.8
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	21,476,699.8		21,476,699.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	250,634.5		250,634.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,727,334.3		21,727,334.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,879,085.9		2,879,085.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,109,387.3		3,109,387.3
Тайлант үеийн үр дүн	-2,153,072.9		-2,153,072.9
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,562,734.6		25,562,734.6





#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>		<b>34,0898.8</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>29,238,024.8</b>	<b>28,923,170.6</b>	<b>314,854.2</b>	<b>98.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,786,024.8</b>	<b>28,472,361.3</b>	<b>313,663.5</b>	<b>98.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>28,319,733.1</b>	<b>28,006,071.0</b>	<b>313,662.1</b>	<b>98.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>21,793,238.7</b>	<b>21,790,752.0</b>	<b>2,486.7</b>	<b>100.0</b>
Үндсэн цалин	14,778,905.0	15,819,802.0	-1,040,897.0	107.0
Нэмэгдэл	6,184,909.5	5,223,718.7	961,190.8	84.5
Унаа хоолны хөнгөлөлт	707,216.7	628,274.0	78,942.7	88.8
Гэрээт ажлын хөлс	122,207.5	118,957.4	3,250.1	97.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,623,221.4</b>	<b>2,617,660.8</b>	<b>5,560.6</b>	<b>99.8</b>
Тэтгэврийн даатгал	1,756,511.6	1,943,095.8	-186,584.2	110.6
Тэтгэмжийн даатгал	216,677.7	171,290.3	45,387.4	79.1
ҮОМШӨ-ний даатгал	173,341.6	139,076.9	34,264.7	80.2
Ажилгүйдлийн даатгал	43,335.8	35,195.6	8,140.2	81.2
Эрүүл мэндийн даатгал	433,354.7	329,002.2	104,352.5	75.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>867,290.7</b>	<b>864,450.4</b>	<b>2,840.3</b>	<b>99.7</b>
Гэрэл, цахилгаан	161,180.5	174,439.9	-13,259.4	108.2
Түлш, халаалт	590,889.1	572,283.5	18,605.6	96.9
Цэвэр, бохир ус	70,993.6	68,040.2	2,953.4	95.8
Байрны түрээс	44,227.5	49,686.9	-5,459.4	112.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,209,206.3</b>	<b>1,208,623.8</b>	<b>582.5</b>	<b>100.0</b>
Бичиг хэрэг	418,116.8	360,835.2	57,281.6	86.3
Тээвэр, шатахуун	274,350.2	287,058.8	-12,708.6	104.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,223.1	333,421.4	1,801.7	99.5
Ном, хэвлэл	5,491.1	6,189.7	-698.6	112.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,695.6	7,355.9	1,339.7	84.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	167,329.5	213,762.8	-46,433.3	127.7
<b>Нормативт зардал</b>	<b>205,143.3</b>	<b>205,045.9</b>	<b>97.4</b>	<b>100.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	205,143.3	205,045.9	97.4	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>680,761.1</b>	<b>680,680.6</b>	<b>80.5</b>	<b>100.0</b>
Багаж, техник, хэрэгсэл	190,134.5	177,284.5	12,850.0	93.2
Тавилга	29,990.0	29,990.0	0.0	100.0
Урсгал засвар	460,636.6	473,406.1	-12,769.5	102.8
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>159,659.3</b>	<b>159,186.3</b>	<b>473.0</b>	<b>99.7</b>
Гадаад албан томилолт	43,303.4	58,803.0	-15,499.6	135.8
Дотоод албан томилолт	105,025.2	88,854.8	16,170.4	84.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	11,330.7	11,528.5	-197.8	101.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>635,167.1</b>	<b>333,631.8</b>	<b>301,535.3</b>	<b>52.5</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	559,762.1	258,398.2	301,363.9	46.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,772.5	4,772.4	0.1	100.0
Даатгалын үйлчилгээ	32,702.7	32,702.6	0.1	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	8,644.2	8,554.3	89.9	99.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,287.6	1,241.6	46.0	96.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,223.5	25,223.5	0.0	100.0
Газрын төлбөр	2,774.5	2,739.1	35.4	98.7
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,045.2</b>	<b>146,039.4</b>	<b>5.8</b>	<b>100.0</b>



Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	33,220.7	33,220.7	0.0	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,824.5	112,818.7	5.8	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>466,291.7</b>	<b>466,290.3</b>	<b>1.4</b>	<b>100.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>466,291.7</b>	<b>466,290.3</b>	<b>1.4</b>	<b>100.0</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	403,791.7	403,791.7	0.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,500.0	62,498.6	1.4	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>452,000.0</b>	<b>450,809.3</b>	<b>1,190.7</b>	<b>99.7</b>
Барилга байгууламж	290,000.0	290,000.0	0.0	100.0
Их засвар	132,000.0	130,819.3	1,180.7	99.1
Тоног төхөөрөмж	30,000.0	29,990.0	10.0	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>29,238,024.8</b>	<b>28,923,170.6</b>	<b>314,854.2</b>	<b>98.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,937,807.4</b>	<b>28,923,170.6</b>	<b>14,636.8</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	28,937,807.4	28,923,170.6	14,636.8	99.9
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>300,217.4</b>	<b>0.0</b>	<b>300,217.4</b>	<b>0.0</b>
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	300,217.4	0.0	300,217.4	0.0
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>2,049.0</b>	<b>2,049.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		145,838.1		
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		486,736.8		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>41.0</b>	<b>41.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	41.0	41.0	0.0	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>1,004.0</b>	<b>1,004.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	51.0	51.0	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	783.0	783.0	0.0	100.0
Үйлчлэх ажилтан	147.0	147.0	0.0	100.0
Гэрээт ажилтан	23.0	23.0	0.0	100.0



## 5 Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.04.25	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Ерөнхий прокурорын газар			САГ-2019/17/СТА-ТЕЗ
				Мянган төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Монгол Улсын Ерөнхий прокурорын Тамгын газар				
Бараа материал дансанд 351 толгой хонь, хургыг нэг бүрийг 6.0-23.0 мянган төгрөгөөр нийт 4,698.0 мянган төгрөгөөр бүртгэсэн	4,698.0	Зөвлөмж	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Ц.Арвинбуудай С.Нямцэвээн
Санхүүгийн тайланд 21.4 мянган төгрөгийн эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй өглөг бүртгэлтэй байна.	21.4	Зөвлөмж	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Ц.Арвинбуудай С.Нямцэвээн
Эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй 76.9 мянган төгрөгийн авлага, өмнөх оноос шилжиж ирсэн 1,654.3 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааны үлдэгдэл тооцоо нийлж буцаан төвлөрүүлээгүй байна.	1,731.2	Зөвлөмж	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Ц.Арвинбуудай С.Нямцэвээн
<b>Дүн</b>	<b>6,450.6</b>			
Тээврийн прокурорын газар				
Санхүүгийн тайлангаар төрийн өмч дансны үлдэгдэл 110,905.9 төгрөг болсон байна. Улс бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгээгүй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
2018 оны 4 дүгээр улиралд 619.8 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан байна. Томилолтоор ажилласан ажилтан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын дагуу мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй байна.	619.8	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
2018 оны шилэн дансны мэдээллийг шалгахад дараах мэдээллүүд дутуу байна. Үүнд: Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/, тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардал, татаас шилжүүлэг		Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Насанжаргал
<b>Дүн</b>	<b>619.8</b>			
<b>Төсвийн шууд захирагчийн дүн</b>	<b>7,070.4</b>			
Улсын ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллага				
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 42 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 32 санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 1 санхүүгийн тайланд "Сөрөг	109,667.2	Зөвлөмж	Харьяа прокурорын газрууд	Харьяа прокурорын газруудын ерөнхий прокурор,



санал”, дүгнэлт өгч, 7 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 2 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан. Аудитаар харьяа газруудын нийт 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 81.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.				нягтлан бодогч нар
<b>Дүн</b>	<b>109,667.2</b>			
<b>УЕП-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт дүн</b>	<b>116,737.6</b>			